БАТЛАВ
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
Ц.ИДЭРБАТ

Чингис хот

# АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭНТИЙ АЙМАГТ 2021 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

2021.03.15

| Үндэсний хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаа | № | Аймгаас хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Эх үүсвэр | Хоёр дахь үе шат (2020-2023 он) | | Хэрэгжүүлэх байгууллага | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Төсөв | Үндсэн | Хамтрагч |
| Нэг. Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх зорилтыг хангах чиглэлээр | | | | | | | | |
| 4.1.1.1. төрийн албаны төв байгууллагын дүгнэлт, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилох тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хариуцлагыг дээшлүүлэх | 1 | Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан дүгнэлтийг томилох эрх бүхий этгээд байгууллагынхаа вэб сайтад ил тод, нээлттэй байршуулах. | 2021 | | Дүгнэлтийг нээлттэй, ил тод болгох ажил хэвшсэн байх | | АЗДТГ | Холбогдох байгууллага |
| | 2 | Төрийн албан хаагчийн нөөцийн бүртгэл болон сул орон тооны мэдээллийг Хэнтий.мн албан ёсны вэб сайтад байршуулах. | 2021 | | Нөөцийн жагсаалт, бүртгэлийг ил тод, нээлттэй байлгах ажил хэвшсэн байх | | ТАЗСЗ | Бүх шатны төрийн байгууллага |
| 4.1.1.7.нийтийн албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх арга хэлбэрийг тодорхой болгож, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх | 1 | Албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Иргэдээ сонсъё 70563111 утсаар мэдээлэл авах үйл ажиллагааг зохион байгуулах. /зурагт хуудас, Шторк/ | 2021 | | Өргөдөл, гомдол, мэдээллийг шуурхай хүлээн авч хэвшсэн байна. | 150.000 | АЗДТГ | Бүх шатны төрийн байгууллага |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2 | ЭБАТ-ны багийг төрийн зарим байгууллагуудад тусгай удирдамжийн дагуу ажиллуулж дотоод хяналтыг сайжруулна. | 2021 | | Дотоод хяналт сайжирсан байна. | | ЭБАТ-ны баг | Бүх шатны төрийн байгууллага |
| | 3 | "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ийг аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа иргэдэд шууд үйлчилгээ үзүүлдэг төрийн байгууллагуудын албан хаагчдад сургалт зохион байгуулах. | 2021 | | Ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагаа жигдэрсэн байна. | | АЗДТГ, ТАЗСЗ | Бүх шатны төрийн байгууллага |
| 4.1.1.9.төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлж, мэдээлэл солилцох нөхцөл, боломжийг сайжруулах | 1 | Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа 187 төрийн байгууллагыг ERP.E-mongolia программд бүрэн холбож мэдээлэл солилцох үйл ажиллагааг тогтмолжуулах. | 2021 | | мэдээлэл солилцох үйл ажиллагааг тогтмолжсон байна. | | АЗДТГ, СЗДТГ | Бүх шатны төрийн байгууллага |
| 4.1.1.10.нийтийн албаны сургалтын институт байгуулах, албан тушаалтныг давтан сургах боломжийг бүрдүүлэх | 1 | Шинээр томилогдсон албан хаагчдад болон төрийн албан хаагчидруу чиглэсэн авлигын эсрэг давтан сургалтыг тухайн жилийн сургалтын төлөвлөгөөнд тусган зохион байгуулах. | 2021 | Орон нутгийн төсөв | Сургалтын ерөнхий төлөвлөгөө батлагдаж сургалт зохион байгуулагдсан байна. | | АЗДТГ, ТАЗСЗ, | Бүх шатны төрийн байгууллага |
| | 2 | Иргэд олон нийтрүү чиглэсэн сургалт, сурталчилгааны ажил болон АТГ-аас гаргасан сурталчилгааны материалуудыг олон нийтэд түгээх ажлыг зохион байгуулах | 2021 | Орон нутгийн төсөв | Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарах нийт албан хаагчийг сургалтад хамруулсан байх | | АЗДТГ, ТАЗСЗ, | Бүх шатны төрийн байгууллага |
| Хоёр. Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж, чанар хүртээмжийг сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр | | | | | | | | |
| 4.1.2.1.төрийн үйлчилгээг иргэнд цахим хэлбэрээр хүргэх тогтолцоог бүрдүүлэн, цахим үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож бэхжүүлэх. | 1 | Төрийн байгууллагаас үзүүлж буй үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэхэд учрах хүндрэл бэрхшээл, шийдвэрлэх арга замыг судалж, цахим хэлбэрт шилжүүлэх боломжтой үйлчилгээг шилжүүлэх арга хэмжээ авах. | 2021 | Орон нутгийн төсөв | Цахим хэлбэрээр үзүүлэх төрийн боломжит үйлчилгээний жагсаалтыг гаргаж цахим хэлбэрт шилжүүлсэн байна. | | АЗДТГ, Засаг даргын дэргэдэх агентлагууд | Бүх шатны төрийн байгууллага |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1.2.2.зөвшөөрөл олгох журмыг хялбарчилж, түүнд тавих хяналтын тогтолцоог бүрдүүлэх, зарим төрлийн зөвшөөрөл олгох, хяналт тавих чиг үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлэх | 1 | Зарим төрлийн хяналт тавих чиг үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлэх арга хэмжээ авах. | 2021 | | Төрийн бус байгууллагад шилжүүлэх зөвшөөрлийг тодорхойлсон байх | | АЗДТГ | Сумын Засаг даргын Тамгын газар |
| 4.1.2.4.эрсдэлд суурилсан төрийн хяналт шалгалт болон аж ахуйн нэгжийн дотоод хяналтыг бэхжүүлэх, хяналт шалгалтын 70 хувийг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулах, чиглэлийг цөөрүүлэх замаар төрийн хяналт шалгалтын тогтолцоог боловсронгуй болгох | 1 | Төрийн байгууллагаас хийж буй Хяналт шалгалтыг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулах, хяналт шалгалтын чиглэлийг цөөрүүлэх. | 2021 | | Хяналтын шалгалтыг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулдаг болсон байх | | АЗДТГ, МХГ | Бүх шатны төрийн байгууллага |
| 4.1.2.7.төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийх, албан хаагчийн үйл ажиллагааг иргэн үнэлэх тогтолцоог нэвтрүүлж, үйлчилгээг сайжруулах | 1 | Иргэдэд шууд үйлчилгээ үзүүлдэг төрийн байгууллагуудын албан хаагчийн үйл ажиллагааг иргэн үнэлэх ухаалаг тогтолцоог нэвтрүүлнэ | 2021 | ОНТ | Иргэн үнэлэх ухаалаг тогтолцоог нэвтрүүлсэн байна. | 150 сая | АЗДТГ | Бүх шатны төрийн байгууллага |
| Гурав. Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр | | | | | | | | |
| 4.1.3.1 .Улсын болон орон нутгийн төсөв, санхүүгийн удирдлагын тогтолцоог сайжруулах, ил тод, нээлттэй, хариуцлагатай байх зарчмыг мөрдүүлэх | 1 | Гадаадын зээл тусламж, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалт болон төсөл, хөтөлбөр, арга хэмжээ бүрийн явц, гүйцэтгэлийг цахимаар хянах орчныг бүрдүүлж, нээлттэй, ил тод болгох. | 2021 | | Хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөрийн явц, гүйцэтгэлийг цахимаар хянах боломжийг судалж, хэрэгжүүлсэн байх | | АЗДТГ, СТСХ | Сумдын Засаг дарга нар, Бүх шатны төрийн байгууллага |
| 4.1.3.4. төсвийн төсөл хэлэлцэхэд олон нийтийн оролцоог хангах | 2 | Орон нутгийн төсвийн төслийн талаар хэлэлцүүлэг өрнүүлэх, төсвийн төсөлд олон нийтийн саналыг авч тусгах зорилгоор Иргэдийн оролцоот Хэтийн Хэнтий арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 2021 | | Орон нутгийн төсвийн төслийг иргэд, олон нийтээр хэлэлцүүлэх нөхцөл бүрдсэн байх | 40 сая | АЗДТГ, ХОХБТХ | Бүх шатны төрийн байгууллага |
| Долоо. Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвх санаачилгыг дэмжих зорилтыг хангах чиглэлээр | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1.7.3.Төрийн байгууллага, түүний удирдлагын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага хяналт тавих боломжийг бий болгох, төрийн зарим ажил үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх, санхүүжилтийг ил тод, үр ашигтай зарцуулах, түүнд хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх | 1 | Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлнэ. | 2021 | | Төрийн бус байгууллага төрийн зарим чиг үүргийг хэрэгжүүлсэн байна. | 1 сая | АЗДТГ, СТСХ | Бүх шатны төрийн байгууллага |
| Арав. Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр | | | | | | | | |
| 4.1.10.1.Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд иргэн, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог хангах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх | 1 | Цахим орчин болон орон нутгийн телевизээр нэвтрүүлэх шторк, нэвтрүүлэг хийх. | 2021 | Орон нутгийн төсөв | Шударга ёсны үзэл санаа нийгэмд төлөвшиж, иргэн өөрт учирч байгаа хүндрэл, бэрхшээлийг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлэх мэдлэгтэй болсон байна. | 1.350.000 төгрөг | АЗДТГ | Сумын Засаг даргын Тамгын газар |
| | 2 | Эссэ бичлэгийн болон гар зургийн уралдаан зарлаж бүтээлүүдийг олон нийтэд сурталчлан таниулах. | | | | | | |